



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 207


Улаанбаатар хот

“Монголиа велт менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.2, 63.1.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 55.1.4, Хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон үйл ажиллагааны журмын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголиа велт менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Монголиа велт менежмент” ХХК /Х.Ганхөлөг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГЭГЧ,
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД